

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 29 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны аравдугаар сарын 23-ны 14 цаг 00 минутад эхэлж, 15 цаг 14 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 14 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д дараах нэмэлт өөрчлөлт, найруулгыг оруулах.</p> <ol style="list-style-type: none">1. Журмын 5.1-ийн 7 дахь заалтын дараа дараах нэмэлтийг оруулах. “8)Байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулж ирсэн байх (тухайн байгууллагын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахын тулд бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, материаллаг бааз, бодлого, үйлчилгээний хувьд хэрхэн хөгжүүлэх, үйл ажиллагааг нь хэрхэн үр дүн, өгөөжтэй байлгах гэх зэрэг)”2. Журмын 7.3 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах. “7.3. Сонгон шалгаруулалтын дүнг нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа Салбар зөвлөл ажлын 3 хоногт, орон нутаг дахь Салбар зөвлөл ажлын 7 хоногт багтаан хуралдаанаар хэлэлцэж, тэнцсэн иргэдээс хамгийн өндөр оноо

		<p>авсан нэг иргэнийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай тогтоол гаргана. Боловсролын газар нэр дэвшүүлэх асуудлаа зохих журмын дагуу шийдвэрлэнэ.”</p> <p>3. Журамд “7.4”, “7.5” гэсэн шинэ заалтуудыг дараах байдлаар нэмэх.</p> <p>“7.4.Сонгон шалгаруулалтын эцсийн дүнг албан тушаал бүрээр нэгтгэн гаргаж, хагас, бүтэн жилээр Салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлд мэдээлнэ. Боловсролын газар дүн, мэдээгээ Салбар зөвлөлд тухай бүр мэдээлнэ.”</p> <p>7.5.Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдол бүрт сонгон шалгаруулалтыг шинээр зохион байгуулна.</p> <p>4. Журмын 9.5-д “журмын “нэг”-ийн 4.1-4.3-т заасан” гэснийг “журмын “нэг”-ийн 1.4-т заасан” гэж өөрчлөх.</p> <p>5. Энэхүү өөрчлөлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд зөвлөмжийн хамт хүргүүлэн холбогдох байгууллагуудад мэдээлэхийг Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажлыг дүгнэх журам батлах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын зургадугаар бүлгийн 6.1 дэх хэсгийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны

		<p>зөвлөлөөс:</p> <p>1. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Журам, үзүүлэлтийг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба \С.Цэдэндамба\нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Иргэн Д.Ганбаяраас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар багийн иргэн Д.Ганбаяраас тус аймаг дахь Салбар зөвлөлийн “Нөөцөд бүртгэх, албан тушаалд нэр дэвшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “б”-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Дорнод аймаг дахь Салбар зөвлөлийн “Нөөцөд бүртгэх, албан тушаалд нэр дэвшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. Дорнод аймаг дахь Салбар зөвлөлийн “Нөөцөд бүртгэх, албан тушаалд нэр</p>

		дэвшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүйд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ